

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАРТ ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БОЛОН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛООР ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ ӨГСӨН ШИЙДВЭРИЙН 2017 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАНИЛЦУУЛГА

/Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд/

2018.02.09

Улаанбаатар хот

## НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэгт “Засгийн газрын гишүүд хагас жил тутам хууль тогтоомж, Улсын Их Хурлаас баталсан бодлогын баримт бичгийн болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, үндсэн чиглэлийн хэрэгжилтийн талаархи тайланг холбогдох Байнгын хороонд ирүүлнэ” гэж заасан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн тайланд шинжилгээ хийж, ирүүлсэн санал дээр үндэслэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд гаргасан хууль тогтоомжийг хяналтаас хасах саналыг хавсарган хүргүүлж байна.

“Монгол Улсын Засгийн газарт хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор үүрэг, чиглэл өгсөн шийдвэрийн 2017 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн танилцуулга”-ыг Улсын Их Хурлын [www.parliament.mn](http://www.parliament.mn) цахим сүлжээнд байршуулсан болно.

## ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ХУУЛИАР ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДЭД ТУСГАЙЛАН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ ӨГСӨН ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

### 2.1. Монгол Улсын хуулийн хэрэгжилт

Улсын Их Хурлын Тамгын газрын Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс 2017 оны эхний хагас жилийн байдлаар Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд хууль хэрэгжүүлэхтэй нийцүүлэн холбогдох дүрэм, журам, жагсаалтыг батлан гаргах үүрэг өгсөн Монгол Улсын 110 хуулийн 544 хэсэг, заалтыг мэдээллийн санд бүртгэж, хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2017 оны эхний хагас жилийн байдлаар Монгол Улсын 77 хуулийн 196 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн нь хяналтанд авсан нийт хуулийн 44 хууль буюу 40.0 хувь, 127 хэсэг, заалт буюу 23.3 хувийнх нь хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн байна. Үлдсэн 33 хуулийн 69 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээний хувьд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас өмнөх онуудад бүрэн хэрэгжиж, хяналтаас хассан хуулиуд байсан бөгөөд хяналтанд авсан 33 хуулийн 348 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй болно.

		Хууль	Хэсэг, заалт
1	2017 оны эхний хагас жилийн байдлаар хяналтанд авсан	110	544
2	Засгийн газраас ирүүлсэн Үүнээс:	77	196
	- Хяналтанд байгаа	44	127
	- Өмнөх онуудад бүрэн хэрэгжиж хяналтаас хассан	33	69
3	Засгийн газраас 2017 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	33	348

Хяналтанд байгаа хуулийн хэрэгжилтийг авч үзвэл, давхардсан тоогоор 14 хуулийн 21 хэсэг, заалт буюу 16.5 хувь нь бүрэн хэрэгжсэн, 17 хуулийн 30 хэсэг, заалт буюу 23.6 хувь нь хэрэгжих шатанд байгаа, 16 хуулийн 51 хэсэг, заалт буюу 40.2 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 10 хуулийн 14 хэсэг, заалт буюу 11 хувь нь хэрэгжээгүй, 4 хуулийн 11 хэсэг, заалт буюу 8.7 хувь нь хугацаа болоогүй байна<sup>1</sup>.

## 2.2. Монгол Улсын хуулиар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд тусгайлан үүрэг өгсөн заалтын хэрэгжилт

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг өгсөн Монгол Улсын 9 хуулийн 57 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн мэдээнд үндэслэн хуулийн хэрэгжилтийг авч үзвэл давхардсан тоогоор 9 хуулийн 22 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлснээс 1 хуулийн 1 хэсэг, заалт буюу 4.5 хувь нь хэрэгжсэн, 8 хуулийн 17 хэсэг, заалт буюу 77.3 хувь нь хэрэгжих шатанд, 4 хуулийн 4 хэсэг, заалт буюу 18.2 хувь нь хэрэгжээгүй байна.

	Хууль /давхардсан тоогоор/	Хэсэг, заалт	
		Тоо	Хувь
Хяналтанд авсан	9	57	100.0
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	9	22	
<b>Үүнээс:</b>			
- Хэрэгжсэн	1	1	4.5
- Хэрэгжих шатанд байгаа	8	17	77.3
- Хэрэгжээгүй	4	4	18.2

## 2.3. Мэдээнд гарсан зөрчил

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн 9 хуулийн 22 хэсэг, заалтаас 7 хуулийн 19 хэсэг, заалт нь хяналтанд байгаа бол хяналтаас хасагдсан 3 хуулийн 3 хэсэг, заалтыг дахин ирүүлсэн байна. Үүнд: Тариалангийн тухай хуулийн 15.7-т заасан *“Тариалангийн газрын атаршуулсан, атар газрыг эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр хагалсан бол буруутай этгээд нөхөн сэргээж, хохирлыг барагдуулна”*, Амьтны тухай хуулийн 24.2-т заасан *“Анчны үнэмлэх олгох, хураах хүчингүй болгохтой холбогдсон журмыг хууль зүй, байгаль орчны болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална”*, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 4.5-д заасан *“Энэ хуулийн 4.1.6<sup>2</sup>-д заасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас төлбөр авах журам, төлбөрийн хувь хэмжээг Засгийн газар тогтооно”* гэсэн хэсгүүд байна.

Мөн Тариалангийн тухай хуулийн 15.7-т заасан *“Тариалангийн газрын атаршуулсан, атар газрыг эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр хагалсан бол буруутай этгээд нөхөн сэргээж, хохирлыг барагдуулна”* гэсэн заалтын хэрэгжилтийг *“газрыг нөхөн сэргээх, хохирол тооцох аргачлал”-ын журмаар*

<sup>1</sup> Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг шинэчлэн баталсан бөгөөд энэхүү журмын 6.3-т заасны дагуу хэрэгжилтийг тооцсон болно.

<sup>2</sup> Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 4.1.6. “Агаарт бохирдол гаргах эх үүсвэр хэрэглэж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага”.

зохицуулагдана, аргачлалыг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн А-202 тоот тушаалаар байгуулан ажиллаж байна” гэж тайлагнаад 100 хувь гэж үнэлж ирүүлсэн байна. Өөрөөр хэлбэл бүрэн хэрэгжээгүй ажлыг бүрэн хэрэгжснээр тайлагнаж ирүүлсэн зөрчил байна.

2016 оны жилийн эцсийн мэдээтэй харьцуулахад 4 хуулийн 7 хэсэг, заалтын хэрэгжилт буурч ирсэн байна. Үүнд: Тариалангийн тухай хуулийн хуулийн 15.8, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 9.5-т заасан “мал, амьтан, ургамал тэдгээрийн гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлтэй холбогдсон журмыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална”, Хүнсний тухай хуулийн 6.2 дахь хэсэгт заасан “Энэ хуулийн 6.1<sup>3</sup>-д заасан стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журмыг Засгийн газар батална” гэсэн заалтуудын хэрэгжилт өмнө нь хэрэгжих шатанд гэж ирүүлж байсан бол 2017 оны хагас жилийн мэдээнд хэрэгжилт буурч 0 хувьтай буюу хэрэгжээгүй гэсэн үнэлгээтэй болсон байна. Мөн Усны тухай хуулийн 24.7, 31.2, 4.8 дахь хэсгүүдийн хэрэгжилт буурсан байна.

Хэлтсийн мэдээллийн санд байгаа 8 хуулийн 37 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

## **ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР**

### **3.1. Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт**

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс 2017 оны эхний хагас жилийн байдлаар Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн Улсын Их Хурлын нийт 63 тогтоолын 179 заалтыг мэдээллийн сандаа бүртгэж, хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2017 оны эхний хагас жилийн байдлаар Улсын Их Хурлын нийт 44 тогтоолын 105 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн байна.

Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг авч үзвэл давхардсан тоогоор 23 тогтоолын 37 заалт буюу 35.2 хувь нь бүрэн хэрэгжсэн, 27 тогтоолын 52 заалт буюу 49.6 хувь нь хэрэгжих шатанд, 6 тогтоолын 12 заалт буюу 11.4 хувь нь хэрэгжээгүй, 4 тогтоолын 4 заалт буюу 3.8 хувь нь хэрэгжих хугацаа болоогүй байна.

### **3.2. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг өгсөн Улсын Их Хурлын 9 тогтоолын 14 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2017 оны хагас жилийн байдлаар тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Улсын Их Хурлын 9 тогтоолын 14 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлснээс давхардсан тоогоор 4 тогтоолын 5 заалт буюу 35.7 хувь нь хэрэгжсэн, 5 тогтоолын 9 заалт буюу 64.3 хувь нь хэрэгжих шатанд байна.

<sup>3</sup> Хүнсний тухай хуулийн 6.1. Хүн амын хүнсний хангамж, хүртээмжийг тогтвортой байлгах зорилгоор стратегийн хүнсний улирлын нөөцийг бүрдүүлнэ.

	УИХ-ын тогтоол /давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
Хяналтанд авсан	9	14	100.0
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	9	14	
<b>Үүнээс:</b>			
- Хэрэгжсэн	4	5	35.7
- Хэрэгжих шатанд байгаа	5	9	64.5

### 3.3. Мэдээнд гарсан зөрчил

Хэдийгээр хяналтад байгаа 9 тогтоолын 14 заалтыг бүрэн ирүүлсэн юм шиг харагдаж байгаа ч хяналтанд байгаа 5 тогтоолын 7 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 6 тогтоолын 7 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлэлгүй орхигдуулсан бол өмнө нь бүрэн хэрэгжиж хяналтаас хасах саналтайгаар ирж хяналтаас хасагдсан 4 тогтоолын 7 заалтын хэрэгжилтийн мэдээг дахин ирүүлсэн байна.

Хэрэгжилтийн хувийг бууруулж тооцох зөрчил байна. Тухайлбал 2016 оны жилийн эцсийн мэдээнд ирүүлж байсан үнэлгээнээс доогуур үнэлж хэрэгжилтийг ирүүлсэн 4 тогтоолын 5 заалт байна. Үүнд: “Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүс байгуулах тухай /2016.05.19 №46/ Улсын Их Хурлын тогтоолын 1.2 дахь заалт “Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүсийн хэмжээ, хилийн зааг, мал эмнэлгийн хяналтын цэгийн үйл ажиллагаа, тариалангийн технологи болон холбогдох бусад журмыг тогтоож, харьяалах төрийн захиргааны тав байгууллагад шилжүүлэх” гэсэн заалтын хэрэгжилт 90 хувиас 70 хувь болж, “Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай /2011.02.10 №11/” Улсын Их Хурлын тогтоолын 5-т заасан “эрчим хүчний үйлдвэрлэлийн шинэ эх үүсвэр 5, 6 дугаар цахилгаан станцыг барих ажлыг 2011 онд эхлүүлэн 2013 онд эхний ээлжийг ашиглалтад оруулж 2014 онд барьж дуусгах”, 12-т заасан “нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах шат дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлснээр 2011-2012 онд шилжих өвөл нийслэлийн агаарын бохирдлыг 50 хүртэл хувиар, 2012-2013 онд шилжих өвөл 80 хүртэл хувиар бууруулж, 2013-2014 онд шилжих өвөл нийслэлийг агаарын бохирдолгүй хот болгох” гэсэн заалтын хэрэгжилтүүдийг өмнөх мэдээнд 70 хувь гэж үнэлж ирүүлж байсан бол 30 хувь болгож бууруулж ирүүлсэн байна.

Мөн 100 хувь бүрэн хэрэгжиж хяналтаас хасагдсан 3 тогтоолын 3 заалтыг дахин хяналтаас хасах саналтайгаар ирүүлсэн байна. Эдгээрт Төрөөс малчдын талаар баримтлах бодлого батлах тухай /2009.06.04 №39/ Улсын Их Хурлын тогтоолын 2.2 дахь заалт, “Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай тогтоолд өөрчлөлт оруулах тухай /2015.01.23 №09/” Улсын Их Хурлын тогтоолын 1 дэх заалт, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай /2011.06.02 №29/ Улсын Их Хурлын тогтоолын 3 дахь заалтуудын хэрэгжилтийг тус тус дахин хяналтаас хасах саналтай ирүүлжээ.

### **ДӨРӨВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛЫН ТАЛААР**

#### 4.1. Байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд 2017 оны хагас жилийн байдлаар Улсын Их Хурлын Байнгын хорооноос Засгийн газарт үүрэг өгсөн нийт 94 тогтоолын 719 заалтыг хяналтанд авснаас 185 заалт хэрэгжиж хяналтаас хасагдаж 534 заалт хяналтад үлдсэн.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2017 оны хагас жилийн байдлаар 37 тогтоолын 159 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн байна. Эдгээр 37 тогтоолын 159 заалтаас 22 тогтоолын 41 заалт буюу 25.8 хувь нь хэрэгжсэн, 27 тогтоолын 99 заалт буюу 62.3 хувь нь хэрэгжих шатанд, 11 тогтоолын 18 заалт буюу 11.3 хувь нь хэрэгжээгүй, 1 тогтоолын 1 заалт буюу 0.6 хувь нь үнэлээгүй ирүүлсэн байна.

#### 4.2. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Засгийн газарт үүрэг өгөгдсөн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 8 тогтоолын 33 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэгдэж хяналтанд авсан. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2017 оны хагас жилийн байдлаар тус Байнгын хорооны 4 тогтоолын 12 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлснээс давхардсан тоогоор 3 тогтоолын 4 заалт буюу 33.3 хувь нь хэрэгжсэн, 3 тогтоолын 7 заалт буюу 58.3 хувь нь хэрэгжих шатанд, 1 тогтоолын 1 заалт буюу 8.3 хувь нь хэрэгжээгүй гэж үнэлж ирүүлсэн байна.

Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	БОХХААБХ-ны тогтоол /давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
Хяналтанд авсан	8	33	100.0
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	4	12	
<b>Үүнээс:</b>			
- Хэрэгжсэн	3	4	33.3
- Хэрэгжих шатанд	3	7	52.1
- Хэрэгжээгүй	1	1	8.3

#### 4.3. Мэдээнд гарсан зөрчил

Хэлтсийн мэдээллийн санд байгаа 8 тогтоолын 33 заалтын хэрэгжилтийг ирүүлээгүй бөгөөд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн 4 тогтоолын 12 заалт нь бүгд өмнө нь хэрэгжиж хяналтаас хасах саналтайгаар ирж хасагдсан заалтууд байна.

Ингэж хяналтаас хасагдсан заалтыг ирүүлэхдээ 2016 оны жилийн эцсийн мэдээнээс хэрэгжилтийг бууруулж тооцож ирүүлэх зөрчил байна. Тухайлбал, Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн чадавхийг бэхжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай /2015.07.09 №07/ тогтоолын 1.2-т заасан “нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийг нэгдсэн зохион байгуулалт, салбар дундын удирдлагаар хангах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэхтэй холбогдуулан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүтцэд нөхөрлөл хариуцсан нэгж ажиллуулах, энэ чиглэлийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх асуудлыг судалж, шийдвэрлэх” гэсэн заалтын хэрэгжилтийг өмнө нь 100 хувь гэж үнэлээд хяналтаас хасах саналтай ирүүлж байсан бол 2017 эхний хагас жилийн мэдээнд хэрэгжилтийг тайлагналгүй 0 хувь болгон үнэлж ирүүлсэн байна.

Мөн 2 тогтоолын 4 заалтын хэрэгжилтийн мэдээний хэрэгжилтийн дүн буурч ирсэн байна. Үүнд: Монгол орны ойн цэвэрлэгээний талаар авах арга хэмжээний тухай /2014.01.15 №04/ тогтоолын 1.4, 1.5 дахь заалтууд, Газар тариалангийн талаар авах зарим арга хэмжээний тухай /2012.09.21 №02/ тогтоолын 1.1, 1.2 дахь заалтуудын хэрэгжилтийг 90 хувиас 70 хувь болгож тус тус бууруулж үнэлж ирүүлсэн байна.

### **ТАВ. БҮРЭН БИЕЛСЭН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗААЛТЫГ ХЯНАЛТААС ХАСАХ ТУХАЙ**

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээн дэх хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд бүрэн хэрэгжсэн Улсын Их Хурлын 4 тогтоолын 5 заалт, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 3 тогтоолын 4 заалтын мэдээг ирүүлсэн байна.

<b>Хууль тогтоомж</b>	<b>Хууль тогтоомжийн тоо</b>	<b>Заалтын тоо</b>
Улсын Их Хурлын тогтоол	4	5
Байнгын хорооны тогтоол	3	4

### **ЗУРГАА. ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР**

Заалтын хэрэгжилтийг хэрхэн үнэлж байгаа нь тодорхой бус, аргачлалын дагуу үнэлдэггүй ирүүлэх зөрчил байна. Өмнө нь “бүрэн хэрэгжиж хяналтаас хасах саналтай” ирүүлж байсан заалтын хэрэгжилтийг 2017 оны хагас жилийн байдлаар “хэрэгжих шатанд” болгож хэрэгжилтийг үнэлсэн байна.

Хууль тогтоомжийн заалтыг хяналтаас хасах тухай саналыг давхардуулж ирүүлэх, хяналтанд байгаа хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийг ирүүлэлгүй орхигдуулах, хэрэгжилтийн мэдээг өөрчлөлтгүй ирүүлэх нийтлэг алдааг хянаж, засаж, цаашид эдгээр алдааг гаргахгүй ирүүлэх талаар чиглэл Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт өгөх нь зүйтэй гэж үзэж байна.

Түүнчлэн хэрэгжилтийг тооцохдоо хяналт-шинжилгээ хийж, үнэлэлгүй, хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээнүүдийн шалтгаан нөхцөлийг тодруулж тайлбарлалгүй өмнөх ирүүлсэн хэрэгжилтийн мэдээг хуулбарлан ирүүлэх зөрчил байна.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ирүүлэхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын дагуу хяналт, шинжилгээ, үнэлгээг хийгээгүй, хэрэгжилт удаашралтай байгаа заалтуудын биелэлтийг сайжруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авч, хариуцсан яамд, агентлагуудад хариуцлага тооцдоггүй байдал нь хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байхад нөлөөлж байна.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээг хагас жил тутам ирүүлэхдээ хугацааны хувьд удаашралтай, 3-4 сарын дараа ирүүлж байгаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд шинжилгээ хийж, холбогдох Байнгын хороонд хүргүүлж байгаа нь хэрэгжилтийн мэдээний ач холбогдолыг бууруулах, хууль тогтоомж бүрэн хэрэгжихгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.

**МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭН ДЭХ  
БҮРЭН ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ЖАГСААЛТ**

/2017 оны хагас жилийн байдлаар/

№	Тогтоолын нэр, огноо, дугаар	Заалтын агуулга	Хэрэгжилт
1	<p><b>Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай</b> 2016-04-14 №35</p>	<p>2.Байгалийн нөөц газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авч байгаа газар нутгийн хилийн заагийг тогтоохыг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т даалгасугай.</p>	<p>“Тусгай хамгаалалтай газар нутгийн тухай” хуулийн 26 дугаар зүйлийн 26.6, Засгийн газрын бүрэн эрх-д “Байгалийн нөөц газрын хилийн заагийг тогтоох” гэж заасны дагуу 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн 91 дүгээр тогтоолоор Тост, Тосон бумбын нурууны байгалийн нөөц газрын хилийн цэсийг 743058.00 га талбайгаар, Ноён уулын байгалийн нөөц газрыг 11187.05 га, Ноён уулын дурсгалт газрыг 650.0 га талбайгаар хилийн заагийг тогтоолоо. Улмаар 3 аймгийн 3 сумын 754,895.05 га буюу нийт газар нутгийн 0.44%-ыг тус тус улсын тусгай хамгаалалтад авч, нийт газар нутгийн 17.85%-д хүрсэн.</p>
2	<p><b>Төрөөс ойн талаар баримтлах бодлого батлах тухай</b> 2015-05-14</p>	<p>2 Төрөөс ойн талаар баримтлах бодлогын зорилтыг хангах цогц хөтөлбөр боловсруулж, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тусган хэрэгжүүлэх, зээл, тусламжид хамруулан, ойн нөөцийн удирдлагын оновчтой бүтцийг бий болгох арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т даалгасугай.</p>	<p>Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэг, Төрөөс ойн талаар баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын 2015 оны 49 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/98 дугаар тушаалаар Төрөөс ойн талаар баримтлах бодлогын зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний дунд хугацаа (2017-2021 он)-ны төлөвлөгөөг боловсруулж батлуулав. Тус төлөвлөгөөнд Монгол орны ойг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах чиглэлийн 5 үндсэн зорилтын хүрээнд 95 багц арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгав. Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулан улсын төсөв, зээл, тусламжид хамруулан ойн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх менежментийн зөв тогтолцоо, удирдлагын оновчтой бүтцийг бий болгох зэрэг арга хэмжээг салбарын хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна. Төрөөс ойн талаар баримтлах бодлогын зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний дунд хугацааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 2017 онд Улсын төсвөөс 5,8 тэрбум төгрөг төсөвлөн, “REDD+д нийцсэн Монгол Улсын Үндэсний Ойн Тооллого”, Монгол-Солонгосын “Ногоон хэрэм”, Монгол орны REDD+ Үндэсний Хөтөлбөр, “Ой бүхий аймгуудийн биологийн олон янз байдлын хамгаалал, ”Ойн тогтвортой менежмент, нүүрстөрөгчийн хийн хуримтлалыг нэмэгдүүлэх”, “Монгол орны ойн ба орон нутгийн ой модны генийн сангийн хөгжил” зэрэг төсөл хөтөлбөрийн дэмжлэг тусалцаатайгаар Төрөөс ойн талаар баримтлах бодлогын зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулж буй ажил, бодлого, зохицуулалтын тухай дэлгэрэнгүй танилцуулгыг УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд 2017 оны 4 дүгээр сарын 28 нд албан бичгээр хүргүүлсэн болно.</p>

3	<p><b>Ногоон хөгжлийн бодлого батлах тухай</b> 2014-06-13 №43</p>	<p>2.2 "Ногоон хөгжлийн бодлого"-д тусгагдсан зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга замыг үндэсний хөгжлийн бодлого, макро эдийн засгийн дунд хугацааны бодлого, чиглэлд тусган хэрэгжүүлэх,</p> <p>2.3 "Ногоон хөгжлийн бодлого"-ын биелэлтийг жил бүр УИХ-д танилцуулж байх.</p>	<p>2016 оны 01 сарын 13-ны Засгийн газрын 35-р тогтоолоор “Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө” батлагдсан. Үйл ажилгааны төлөвлөгөөг үндэсний хөгжлийн бодлого, дунд хугацааны төлөвлөлтөд тусган хэрэгжүүлж байна. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд "Ногоон хөгжлийн бодлого"-д тусгагдсан зорилго, зорилтыг тусгасан болно.</p> <p>"Ногоон хөгжлийн бодлого"-ын биелэлтийг гарган 2017.05.01-ны өдрийн 01/2482 тоот албан бичгээр БОХХАА-н Байнгын хороонд хүргүүлсэн болно.</p>
4	<p><b>Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” тогтоолд өөрчлөлт оруулах тухай</b> 2015-01-23 №09</p>	<p>1.1 Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын цахилгаан эрчим хүчний үнэд хөнгөлөлт үзүүлэх урамшууллын шалгуур, хэлбэр, цаг, хувь хэмжээг тогтоож, зөрүүг улсын төсвөөс санхүүжүүлэх.</p>	<p>Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор цахилгаан халаагуур, стандартын шаардлага хангасан дулаалга, хийн түлш, сэргээгдэх эрчим хүч, шахмал болон хагас коксон түлш, сайжруулсан зуух, яндангийн шүүлтүүр хэрэглэж байгаа айл өрхөд цахилгааны үнийн урамшуулал, хөнгөлөлт олгох талаар “Агаарын тухай” хуулийн 6.1.6, “УИХ-ын 2011 оны 11-р тогтоол”, “МУ-ын ЗГ-ын Журам батлах тухай 309-р тогтоол”, “Эрчим Хүчний Зохицуулах Хорооны зохицуулагчдын зөвлөлийн тогтоол”-д тус тус заасан. Дээрхи шийдвэрүүдийн дагуу 2011 онд 21 мянга, 2012 онд 49 мянга, 2013 онд 66 мянга, 2014 онд 69 мянга, 2015 онд 105 мянга, 2016 онд 109 мянган хэрэглэгчийн шөнийн тарифыг 50 % хөнгөлж энэ хугацаанд нийт 11.2 тэрбум төгрөгийн урамшуулал үзүүлсэн байна.</p> <p>Улаанбаатар хотод цахилгаан эрчим хүчинд холбогдсон, гэрээ байгуулсан нийт 147353 гэр хорооллын хэрэглэгч байсны 75 хувь буюу 110895 хэрэглэгч 2 тарифт тоолууртай бөгөөд 2017.01.01-ний өдрөөс эхлэн шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны төлбөрийг 100 хувь хөнгөлсөн. Нийслэлийн гэр хорооллын 2 тарифт тоолууртай айл өрхийн оройн 21:00 цагаас өглөөний 06:00 цаг хүртэл хэрэглэсэн цахилгааны тарифыг 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 4 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд 100 хувиар хөнгөлөх шийдвэрийг гаргасны дагуу өнгөрсөн хугацаанд 3,363.7 сая төгрөгийн хөнгөлөлтийг олгоод байна.</p>
<p align="center"><b>Нийт Улсын Их Хурлын 4 тогтоолын 5 заалтыг хяналтаас хасах саналтай байна.</b></p>			

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
БҮРЭН ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ ТОГТООЛЫН ЖАГСААЛТ**  
/2017 оны хагас жилийн байдлаар/

№	Тогтоолын нэр, огноо, дугаар	Заалтын агуулга	Хэрэгжилт
1	<b>Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн чадавхыг бэхжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай</b> 2015-07-09 №07	3. Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн үйл ажиллагаанд олон улсын туршлага, арга зүйд үндэслэсэн, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт арга технологи, менежментийг нэвтрүүлэх, шаардлагатай бага оврын тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангахад чиглэсэн санхүүгийн дэмжлэг, хөнгөлөлт үзүүлэх төсөл, хөтөлбөрийг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх.	<p>НҮБ-ын ХХААБ-аас хэрэгжүүлж байгаа “Ойн тогтвортой менежмент, биологийн олон янз байдлын хамгаалал ба нүүрстөрөгчийн хийн хуримтлалыг нэмэгдүүлэх” төслийн хүрээнд Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Дархан–Уул, Хэнтий зэрэг аймгийн 102 нөхөрлөлийг сонгож, хамтын оролцоотой ойн менежментийг нэвтрүүлэх ажлыг эхлүүлэн нөхөрлөлүүдийг чадавхижуулах ажил хийгдэж байна. “Ойн тогтвортой менежмент хэрэгжүүлж нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх” төслийг ядуурлыг бууруулах Японы сангаас санхүүжилтээр Азийн хөгжлийн банкаар дамжуулан хэрэгжүүлэхээр төслийг батлуулсан.</p> <p>Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн үйл ажиллагаанд олон улсын туршлага, арга зүйд үндэслэсэн, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи, менежментийг нэвтрүүлэхийн тулд НҮБ-н UN-REDD хөтөлбөр, НҮБ-н ХХААБ /FAO/, НҮБ-н Хөгжлийн хөтөлбөр /UNDP/, ГОУХАН /GIZ/, Солонгосын “Ногоон хэрэм” Дэлхийн зөн ОУБ, Азийн Хөгжлийн Банк зэрэг олон улсын байгууллага төсөл хөтөлбөрүүдтэй хамтран дараахи үйл ажиллагааг явуулж байна.</p> <p>1. MRPA-төсөл: 32 нөхөрлөлийг хамруулсан дараах танилцах аялал зохион байгуулав.</p> <ul style="list-style-type: none"> <li>-Хустайн БЦГ-ын ТХГН-ийн хамтын менежмент, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын менежментийн чиглэлээр туршлага судлах аялал</li> <li>-Хэнтий аймгийн Норовлин, Дорнод аймгийн Баян-уул, Цагаан-овоо сумдын нөхөрлөл хил залгаа орших Дадал, Биндэр, Батширээт сумдын нөхөрлөлүүдийн тэргүүний туршлагауд, ажлын арга барилтай танилцах аялал</li> <li>-Нөхөрлөлийн гишүүдэд зах зээлийн шаардлагад нийцсэн сүү, сүүн бүтээгдэхүүнийг бэлтгэх, савлах арга ажиллагаанд сургах, боловсруулсан бүтээгдэхүүнээ борлуулах зах зээлийг нээж илрүүлэх, туршлага олгох аялал</li> <li>-Увс аймгийн Сагил, Бөхмөрөн сумын Гулзат ОНТХГ-ын нөхөрлөлүүд, Ховд аймгийн “Хар ус нуур” БЦГ-ын орчны бүс дэх Буянт сумын малчдын бүлэг, нөхөрлөлөөс нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын менежментийн чиглэлээр туршлага судлах аялал.</li> </ul> <p>2. Азийн хөгжлийн банкны төсөл:</p> <ul style="list-style-type: none"> <li>-Ногоо тарих сургалт, Бага оврын завь, катер жолоодогч нарт зориулсан сургалт, Малчдын бүлэг байгуулах сургалтууд.</li> </ul>
2	<b>Мазаалай баавгайг хамгаалах арга хэмжээний тухай</b> 2013-05-30 №16	2. Шинжлэх ухааны академийн Биологийн хүрээлэнд хийгдэж буй мазаалай баавгайн биологи-экологи болон	АНУ-ын Айдохогийн Их сургуульд 6 сарын хугацаанд ажиллаж мазаалай баавгайн ангилал зүйн асуудлыг тодорхойлов. Судалгааны ажлын үр дүнд мазаалай нь хүрэн баавгайн салбар зүйл дотроо бие даасан ялгаатай дэд зүйл болох нь батлагдав. ШУА-ын Биологийн хүрээлэнгийн эрдэмтэдтэй гэрээ байгуулан мазаалай баавгайн амьдрах орчны загвар боловсруулах ажлыг хийж гүйцэтгэв. Мазаалай баавгайн биологи-экологи болон генетикийн судалгааны ажлыг

		генетикийн судалгааны ажлыг эрчимжүүлэн лабораторийн материаллаг баазыг бэхжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авах.	эрчимжүүлэн лабораторийн материаллаг баазыг бэхжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор 10 гаруй сая төгрөгийн дэмжлэг тусламжийг АНУ-ын Айдохогийн Их сургуулиас авч хэрэгжүүлэв. Сансарын долгион дамжуулах хүзүүвч ашиглан мазаалай баавгайн шилжилт хөдөлгөөн, тархац нутаг, эзэмшил нутаг, ичээ тодорхойлох судалгааны ажил Олон улсын баавгай судлалын нийгэмлэг, ШУА-ийн Биологийн хүрээлэнтэй хамтран хийж гүйцэтгэсэн. Мазаалай баавгайн генийн судалгааг ШУА-ын Биологийн хүрээлэнгийн судлаачид АНУ болон БНЭУ-д хийж судалгааны үр дүнг олон улсын эрдэм шинжилгээний бүтээлд хэвлүүлэв. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас мазаалай баавгайн судалгаанд шаардлагатай болон бусад арга хэмжээний төсөвт жил бүр 40-50 сая төгрөгийг төсөвлөж, шаардлагатай зөвшөөрлийг олгож байна. Мазаалай баавгайн амьдрах орчныг сайжруулах, Мазаалай баавгайг зориудаар үржүүлэх БНХАУ-ын тусламжаар төсөл хэрэгжүүлэх гэрээнд гарын үсэг зурж, ажил эхлэн, хэрэгжилт тогтмолжив.
		3. Мазаалай баавгайг хамгаалах, өсгөн үржүүлэх ажилд орон нутгийн удирдлага, иргэд, төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог дэмжиж хамтран ажиллах.	Мазаалай хамгаалах үйл ажиллагаанд орон нутаг болон төрийн бус байгууллагын оролцоог дэмжиж ажиллах хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг гэрээгээр гүйцэтгүүлэн, Баянхонгор, Говь-Алтай аймгуудын удирдлагуудтай мазаалай хамгаалах, амьдрах орчныг тэтгэх чиглэлээр уст цэг байгуулах, тэжээлийн сав, тэжээл үйлдвэрлэх зэрэг ажлуудыг хамтран гүйцэтгэж байна. Говь-Алтай аймаг Мазаалай баавгайд нэмэлт тэжээл тавьж өгөх асуудлыг жил бүр гүйцэтгэж байна. Мобиком, Бодь даатгал, Мамо ТББ, Монголын бартаат замын авто спортын холбоотой хамтарсан албан бус ажлын хэсэг байгуулан нэмэлт тэжээл тавих, судалгааг санхүүжүүлэх, сурталчилгааны ажлыг хийж хэвшсэн байна.
3	<b>Газар тариалангийн талаар авах зарим арга хэмжээний тухай</b> 2012-09-21 №02	2.2 Чанар сайтай хүнсний буудайн хүрэлцэхүйц нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, стандартын шаардлага хангасан элеватор, агуулахад хадгалах, хадгалалтын явцад хяналт тавьж ажиллах.	Улсын хэмжээнд 538.0 мянган тоннын багтаамжтай 19 элеваторын цогцолбор байгууламж ажиллаж байна. Үүнээс Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 182.0 мянган тонн, гурилын үйлдвэрүүдийн 276.5 мянган тонн, тариалан эрхлэгч аж ахуйн нэгжийн 80.0 мянган тонн багтаамжтай элеватор байна. Жил бүр элеваторуудад агуулахын ариутгал халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагуудаар гүйцэтгүүлж, агуулахын засварыг бүрэн дуусгаж нөөцийн буудайг хүлээн авах бүрэн хийгдсэн. Мөн түүнчлэн хүнсний буудайн хадгалалтын явцад Мэргэжлийн хяналтын ерөнхий газар улирал тутамд хяналт тавьж, дүгнэлт гарган ажиллав. 2016 оны ургацаас ТЭДС-д 69.0 мянган тонн, Алтан тариа ХХК 90.0 мянган тонн, Улаанбаатар гурил ХХК 80.0 мянган тонн бусад гурилын үйлдвэрүүд 63.4 мянган тонн, нийтдээ 292.4 мянган тонн хүнсний буудайг хүлээн авч нөөц бүрдүүлэв. 2016 оны ургацаас Тариалан эрхлэлтийг дэмжих санд 69.0 мянган тонн хүнсний буудайн нөөц бүрдүүлсэн бөгөөд эхний 30.0 мянган тонныг нь гурилын үйлдвэрт борлуулаад байна. Хүнсний буудайн хадгалалтад байнгын хяналт тавьж Тариалан эрхлэлтийг дэмжих сантай хамтран ажиллаж байна.
<b>Нийт 3 тогтоолын 4 заалтыг хяналтаас хасах саналтай байна.</b>			